

Монгол гэрийн хөгжлийн судалгааны зарим асуудалд

Бай Мандуулт^{1, *}

Товч агуулга: Монголын өндөрлөгт эрт үеэс аж төрсөн сууж ирсэн нүүдэлчин ард түмний бүтээсэн соёлын үнэт өвийн нэг бол монгол гэр билээ. Нүүдлийн соёл иргэншилт монголчуудын ахуй байдалд тохирсон сууц болох монгол гэр нь угсаатны эдийн соёлын түүхэн хөгжил, өвөрмөц онцлогийг илтгэн харуулахын зэрэгцээ оюуны соёлын асар их өвийг хадгалж байдаг. Монгол нүүдэл соёлын бэлгэдэл болох монгол гэрийн түүх, соёлын ач холбогдол, бүтцийн өвөрмөц онцлог, орчин үеийн нийгэмд гарч буй өөрчлөлтийг судалснаар бид үндэсний хэв шинж, орчин үеийн мэдрэмжийг хадгалсан архитектурын бүтээлийг бий болгож чадна.

Түлхүүр үг: Монгол гэр, архитектур, тогтвортой хөгжил, уур амьсгалд дасан зохицох чадвар

Удиртгал

Хүн төрөлхтний орон байрны чухал хэлбэрийн нэг бол гэр мөн. Гэр үүсэн хөгжсөн процессыг эрдэмтэд тогтоохдоо юуны өмнө малчин аймаг, анчин гөрөөчин хэсгээсээ ялгаран салсан үетэй нягт холбон үздэг. Монгол гэр нь нийгэм соёлын үүднээс авч үзвэл нүүдэлчдийн ахуй байдалд тохирсон, хүн, байгальтай зохицон оршихуйн үзэл санааг шингээсэн байдаг. Монголчууд ба тэдний нэн эртний өвөг дээдэс хадны нөмөр, агуй, нүхэн гэр, урц овоохойноос олон зууныг элээж байж урт удаан хугацаанд өөрийн оршин ахуйдаа нэн тохирсон орон сууц – гэрийг үүдэн бүтээжээ. Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд, Монголын өндөрлөгт дугуй хэлбэртэй хагас нүхэн сууц шинэ чулуун зэвсгийн сүүл үеэс бий болсон бөгөөд ханат гэр үүсэх процесс мал аж ахуйг эрхлэхээс олон зуун жилийн өмнөх хүмүүсийн амьдралын хэрэгцээгээр үүсээд аажим хугацаанд биеэ даасан хийц хэсэглэл болж хөгжих замд оржээ (Майдар, Дарьсүрэн 1976: 77). Хүннүгийн үед эсгий гэрийн технологи нэгэнт боловсорсонгүй болсон байна. Монголчуудын эртний дээдсийн тоонот гэр нь бургасан ханатай, эсгий бүрээстэй, хялгасан бүслүүртэй, нутаг орондоо элбэг байдаг материалыг ашиглан хийсээр иржээ (Гай Шанлин 1986). Монгол улсын нутгаас олдсон Хүннүгийн эдлэл дээрх гэрийн зураг, Түрэгийн тахилын онгон, БНХАУ-ын Өвөр Монголд судалсан Хятаны бунхант булшны чулуун хавтан, вааран гэр зэрэг археологийн олдворууд нь монгол гэрийн хөгжил, стандартчиллын үйл явцыг судлах чухал сурвалж юм. Их Монгол хаант улсын

үеэс нүүдэлчдийн эзэнт улсын хүрээ тэлэхийн хэрээр гэртэй холбогдох зан үйл, орон зайн хуваарилалт нь улс төр, соёлын гүн гүнзгий агуулгатай болж хөгжсөн түүхтэй.

Монголын нүүдэлчин соёлын өвөрмөц бэлгэ тэмдэг болсон монгол гэр нь олон мянган жилийн турш байгаль цаг уур, эрс тэс уур амьсгалд төгс зохицож иржээ. Дэлхий дахинд экологи, байгаль орчны асуудал хурцаар тавигдаж, тогтвортой хөгжил нь цаг үеийн сэдэв болоод байгаа өнөө үед хүн төрөлхтний тогтвортой хөгжлийн эрэл хайгуул хэзээ ч зогссонгүй.

Хятад сурвалж дахь эртний монгол гэрийн нэршлийн тухай

Нүүдэлчдийн эртний гэр орон сууцны талаар хөрш зэргэлдээх орны түүх бичигт янз бүрийн цаг үед өөр өөр нэршлээр тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал, “Хань улсын судар”-ын “Хүннүгийн шастир”-т гэрийн тухай өгүүлэхдээ: “Хүннүгийн эцэг хөвгүүд нэг Чионглу (穹庐)-д унтдаг” гэж тэмдэглэсэн байдаг. Зарим эрдэмтний үзэж буйгаар, “Чионглу” нь “qiong’lu” гэдэг хүннү үгийн галиглал бөгөөд “эсгий майхан” гэсэн утгатай аж (Хуан Вэйжунг 2022). “Сүй улсын судар: Түрэгүүдийн шастир”-т, түрэгүүд “мах сүүгээр хоол унд болгон ... эсгий майханд суудаг” гэж бичсэн байна. Хятадын эртний түүх сударт дурдагдсан энэ “Чионглу” буюу “эсгий майхан” гэдгийг хожмын монгол гэрийн эртний хэлбэр мөн гэж судлаачид үздэг (Вэй Жэнг 1962: 241).

Вэй, Жин, Өмнөд, Умард төрийн үед хятадууд Сяньбийн эсгий гэрийг “Бай Зи” (百子帳) гэсэн үгээр тэмдэглэжээ. Сурвалжид, “хэдэн зуун уньтай Бай Зи (百子帳) байдаг” (Хуан Вэйжунг 2022), “Олон уньтай

¹ МУБИС, Дүрслэх урлаг, технологийн сургуулийн докторант

* Холбоо барих зохиогч: 475428595@qq.com

гэр барихын тулд долоон тэрэг бэлтгэх хэрэгтэй” (Чен Жинью, Ли Лианмэн 2013) гэсэн нь олон хүн багтах уужим зайтай том гэрийг хэлж байна. Умард Вэй улсын сурвалжид, ийм “олон унтай” том гэрийн тухай бас өгүүлж байдаг. Тухайлбал, Умард Вэй улсын эзэн хаан Сяомин (孝明帝) Роуран (柔然, rou`ran) буюу Жужанчуудад нэг удаа 18 ширхэг их гэр буюу Бай Зи (百子帐) бэлэглэж байжээ. Умард Вэй улсыг хүртэл Сяньбичууд ерөнхийдөө нүүдэлчин ба суурьшмал гэсэн хоёр төрлийн амьдралын хэв маягтай болоод байжээ (Мэн Чунрун, Тянь Жяшин 2023: 167, 169, 170).

Ляо улсын Хятанчуудын нийгэм, зан заншил Нанхиад үндэстнийхээс өсөд өөр байсан. Амьдралын онцгой хэв маягийн нэг нь дөрвөн улиралд ашигладаг “Набо” байв. Ляогийн эзэн хаан олон түшмэдийн хамт төв засгийн газрыг тэргүүлэн жилийн турш янз бүрийн газраар аялан явж ав хоморго хийдэг. Түүний нүүдлийн ордон сууцыг “Набо” [nà bō] гэж нэрлэсэн байдаг (Редакцийн хэлтэс 1992: 161-162).

Юань улсын сурвалжуудад үндсэндээ хоёр төрлийн сууцны нэрийг тэмдэглэсний нэг нь “Гэ ри” буюу монголоор “гэр” хэмээх жижиг сууц, нөгөө нь “орд” хэмээх их асрыг зааж байна. “Гэр” -ийг Хятадын түүхэн материалд “Чионглу” (穹庐) , “Лу Жан” (庐帐) , “Цуй Му” (毳幕cui mù) гэж өөрөөр бас нэрлэсэн байдаг. “Монголын Нууц Товчоо”-ны хятад галигт “Гэр” (格儿) гэж бичсэн бөгөөд энэхүү сурвалж бичигт, өвсөн нэмбүлэгээс авахуулаад алтан тэрэм, аураг орд, ханат гэрээс авахуулаад хадан гэр хүртэлх монголчуудын гэрийн тухай, түүнтэй холбоотой ойлголт сэтгэлгээг гүн гүнзгий агуулгаар өгүүлсэн байна.

Монголчуудын “орд” (斡耳朵) гэдэг нь тэдний ноёд, ван нарын хэрэглэж байсан “гэр”-ийн нэршил болно. Хятадын түүхийн материалд “幄殿” буюу “майхан танхим”, “毡殿” буюу “эсгий танхим”, “том майхан” гэх зэргээр нэрлэсэн бол Юань, Мин улсын түүхийн материалд “窝里陀” Волидуо” (Орд), “兀鲁朵 Өлүдо” (Орд), “斡如格” (Өргөө) гэх мэтээр нэрлэсэн байна. “Орд” гэдэг нь ерөнхийдөө хаад язгууртны суух өргөөг хэлсэн хүндэтгэсэн хэллэг бол Түрэг, Хятан, Монгол, Манж хэлэнд “Орд” заримдаа “харш” эсвэл “хуаран” гэсэн утгаар өргөжиж хэрэглэгдэж байжээ. Манж Чин улсын Энх Амгалан хааны (Канси) үед монгол бичгээр “Монгол гэр”, хятад бичгээр “蒙古格利” гэдэг үг аль аль нь монгол гэрийн нэршил байжээ (Эрдэмт 2022). Найралт төв хааны (Юнжэнг) эхний жилд угсаатны нэр “Монгол” ба Манж хэлээр “бао” (гэр) гэсэн үгийг нийлүүлж хэрэглэх болсон. “Хааны өрхийн журганы эмхэтгэл” (内务府造办处 档案) бичигт: “Монгол гэрт нанму мод түшлэгтэй ор хийсэн” гэж тэмдэглэсэн байдаг (Хятадын анхны түүхийн архив 2007).

2023 оны 5-р сард Өвөр Монголын Ордос хотод Ханжин хошуунд зохиогчийн хийсэн хээрийн судалгаа ярилцлагаас үзэхэд, Чин улсын сүүл үеийн үед, монгол гэр нь ханын тоогоор өөр өөр нэртэй байжээ. Чинээлэг айлын дөрвөн ханатай монгол гэр нь охид, хүүхдүүдийн амьдрах зориулалттай байсан бөгөөд “Гэр” гэж хэлдэг. Зургаан ханатай гэрийг өндөр настангууд суух юм уу, бурхан тахих зориулалтаар ашигладаг бөгөөд “Өргөө” гэж нэрлэдэг. Найман ханатай гэрийг төрийн албанд хэрэглэглэх бөгөөд “Орд” гэж нэрлэдэг. Арван ханатай гэрт ноён, язгууртан хүн суух бөгөөд “Харш” гэж нэрлэдэг уламжлал байжээ.

Монгол гэрийн нэршилд ханын тоогоор ялгах үзэгдлийг Эрдэмт бээр “Монголын гэрийн архитектурын түүх: XIII зуунаас XX зууны дунд үе хүртэл” зохиолдоо тэмдэглэснээс үзвэл, Чин улсын үед монголчуудын гэрийн хэмжээ нь зөвхөн хэлбэр дүрсээрээ бус, харин мөн анги давхаргын тогтолцооны хуваагдлыг илэрхийлж байжээ. Найман ханатай гэр нь иргэний орон сууцанд хамгийн томд орох боловч албан архитектур, хааны гэр бүлийнхний хувьд хамгийн жижиг нь байсан ажээ (Эрдэмт 2022).

Янз бүрийн угсаатны бүлэг, бүс нутгуудад байрлах Монголын гэрийн нэршлийн ялгаа нь гэрийн хэлбэр, гар урлалын хувьсалтайгаа нягт холбоотой байдаг. Эдгээр нэршлийн өөрчлөлт нь Хүннүгийн үеийн “Чионглу”, Түрэг хэлний “Юрт”-ээс Монгол хэлний “Гэр” хүртэл, хэл шинжлэлийн өөрчлөлтийг тусгах төдийгүй нүүдэлчин ард түмний архитектурын технологийн үе шаттайгаар хөгжиж байсныг илтгэж байна. Нэршлийн системд нь этимологийн судалгаа хийснээр нүүдэлчин нийгмийн өөр өөр түүхэн цаг үеийн оршин суух суурьшлын хэв маягийн хувьслыг судалж, улмаар түүний соёлд дасан зохицох стратеги, нийгмийн зохион байгуулалтын онцлогийг олж харах боломжтой. Энэхүү судалгаа нь нүүдэлчдийн соёл иргэншлийн архитектурын мэргэн ухааныг ойлгох, өвөрмөц өнцгөөс судлах суурь судалгаа болж болно.

Монгол гэрийн дүрс хэлбэрийн үүслийн асуудалд

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд, ханат гэр барагтцаалбал НТӨ 3000 жилийн тэртээ үүсчээ. Монголын өндөрлөгт нүүдэлчдийн иргэншил хөгжихийн хэрээр Хүннү, Сяньби, Жужан, Түрэг зэрэг эртний нүүдэлчин ард түмэн урт хугацааны үйлдвэрлэлийн практикт энэхүү уламжлалт сууцны хэлбэрийг сайжруулж, төгөлдөржүүлсээр ирсэн байна. Эртний энгийн дугуй урц овоохойноос суурилуулах буулгах боломжтой эвхдэг модон хана, нарийн төвөгтэй тооно (дээврийн цонх) хийц бий болсон нь нүүдэлчин ард түмний байгаль орчинд

дасан зохицох хөгжил, технологийн шинэчлэлийн үйл явцыг тод харуулна. Энэхүү хувьслын үйл явц нь технологийн дэвшил төдийгүй нүүдэлчдийн соёлын хөгжлийн чухал судлагдахуун юм.

Монгол нутагт байсан эртний нүүдэлчдийн сууцны тухай сурвалж бичгийн анхны мэдээ Хүннү нарт холбогдоно. Хүннүгийн гэрийн хэлбэрийг Хятадын түүхийн материалд тэмдэглэхдээ: “Гэр (穹庐) нь бөмбөгөр дээвэртэй, дугариг хэлбэртэй” гэжээ. Сяньбигийн гэр нь модон ханатай, унь, эсгий бүрээстэй, тооно, үүд, хаалга бүхий бөмбөгөр хэлбэртэй байжээ. Үүнийг Хятадын түүхийн материалд “Бай Зи (百子帐)” гэж нэрлэж байжээ. Вэй, Жинь, Өмнөд, Умард төрийн үед Сяньбичуудын эсгий гэр нь “Бүслүүр уяатай, модон ханатай, бөмбөгөр оройтой, дугуй хэлбэртэй, хөх өнгийн торгон бүрээстэй, зуун хүн багтах уужим зайтай “澈” буюу “Бай Зи (百子帐)” гэж тодорхойлсон байна (Жан Тонг 2001: 52-56).

Хятад сурвалж бичигт, умардын ди аймаг Жужанчуудыг хээр талаар өвс усны аясыг даган нүүдэг, гэр тэрэг хэрэглэдэг, дайнд мордохдоо гэр орон, эд хогшлын хамтаар явдаг, зугтан сарнихдаа мал сүргийн хамтаар явдаг тул хоол хүнсээр дутагдахгүй гэж тэмдэглэжээ. “Сүй улсын судар: Түрэгүүдийн шастир”-т, түрэгүүд “мах сүүгээр хооллон, эсгий гэрт суудаг...” гэж бас адилхан бичсэн байна (Вэй Жэнг 1962). Археологийн судалгаагаар, монголчууд эрт үеэс нас барагсдаа оршуулахдаа нөгөө ертөнцөд өөрийн гэр оронтойгоо байхаар төсөөлөн бодож, гэрийн ямар нэг эд зүйлийг дагалдуулан оршуулах, загвар гэр хийх, эсвэл гэр хэлбэрийн бунханд оршуулах заншил түгээмэл байжээ (Эрдэнэбат, Амартүвшин 2010).

Эртний гэрийн янз бүхийн дүрслэлийг харилцан адилгүй цаг үеийн оршуулгын хэрэгсэл эсвэл хадны зураг сийлмэл дээрээс ихэвчлэн олж хардаг. Археологийн материалууд нь эртний монгол гэрийн архитектурын хэлбэрт диахронины илэрхий ялгаа байгааг харуулна. Типологийн үүднээс авч үзвэл түүний хувьслын дарааллыг сэргээж болно. Жишээ нь: 1. Өвөр Монголын Алшаа аймгийн Мандела уулын хадны зураг, 2. Монгол улсын нутгаас олдсон Хүннүгийн булшны олдворууд; 3. Өвөр Монголын Хорчин баруун гарын дундад хошууны Сяньбигийн булшнаас олдсон оршуулгын хэрэгсэл вааран гэр, 4. Монгол улсын Хэрлэн голын сав газраас олдсон Түрэгийн хавтан чулуун дээрх гэрийн сийлмэл зэргийг дурдаж болно. (Лхүндэв нар 2024: 148). Эдгээр баримтууд нь “Шижи - Түүхийн тэмдэглэл: Хүннүгийн шастир”-т “Чионглу гэрт амьдрах” гэсэн тэмдэглэгээг баталгаажуулаад зогсохгүй, олдворын хэлбэр судлалын харьцуулсан судалгаагаар нүүдэлчдийн архитектурын технологийн гурван үе шаттай хөгжлийн хэв маягийг: Энгийн дугуй орон сууц → Суулгах, задлах боломжтой бүтэц → Олон

нэгдэл ордны майхан систем хөгжсөнийг харуулж буй.

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Хишигтэн хошууны Ляо улсын үед холбогдох Эрбади хадны зурагт, бөмбөгөр хэлбэртэй Чионглу чандрын сав, бунхны бөмбөгөр таазны ханын зургууд нь тэр үеийн гэр нь бөмбөгөр оройтой, доод талдаа сууриараа тэг дугуй хэлбэртэй байсныг тод харуулсан. Энэ мэт олон баримтаас IX зуунаас XVI зуун хүртэл хятад сурвалжид дурдсан “Бай Зи (百子帐)” нь хүзүүвчин тоонотой эсгий гэр байсан агаад тооно хэсэг нь цорго хоолой мэт шомбогор оройтой байсныг заасан гэж үзэж болно. Хятаны хаад, язгууртны суудаг асар янз бүрийн хэлбэртэй, гоёмсог хийц загвартай байсан. Эртний зургаас үзэхэд, дугуй хэлбэртэй, олон тулгууртай, бөмбөгөр, бас дөрвөлжин хэлбэртэй асар майхан байдаг. Хүрэн дотор буй холболдсон гэрүүд нь ихэвчлэн нэг эсвэл хоёр төв цачир, хэд хэдэн туслах майхнаас бүрддэг бөгөөд олон янз байдаг.

“Монголын Нууц Товчоо”-нд тэмдэглэсэн, монголчуудын орон сууцны нэршлийг дурдвал, өвсөн нэмбүлэ гэр, чорхан гэр, гэр тэрэг, орд гэр, алтан тэрэм, өргөө гэр, шилтэсүтэй гэр, гэрлүг, бургасан гэр гэх зэргээр нэрлэсэн нь цөм гэр хэлбэрт багтах сууц байжээ (Баатархүү, Одсүрэн 2015). XIII зуунд Монголд ирсэн жуулчдын тэмдэглэлд, Плано Карпини (Giovanni da Pian del Carpine)-гийн хэлснээр, монголчуудын сууц нь дугуй хэлбэртэй гэр бөгөөд хавтгай болон нарийн саваа модыг эвлүүлэн барьдаг. Гэрийн дээд талын төв дунд нэгэн дугуй онгорхой байх бөгөөд түүгээр гэрэл гэгээ орохоос гадна гэрийн голд түлэх галын утаа гарна. Хана дээврийг эсгийгээр хулдах ба үүдээ мөн эсгийгээр хийнэ. Зарим гэр нь том, зарим нь төдий л том бус байх бөгөөд гэрийн эзний чадал чинээг заана. Зарим гэрийг амархан буулгаж хурааж, ачиж тээж болдог байхад зарим нь огт буулгаж болдоггүй зөвхөн тэргэн дээр бариастай нь зөөнө” гэжээ (Ли Хуэйз, Гао Сяошиа 2017).

Францын номлогч Рубрук (Guillaume de Rubrouck)-т бүртгэгдсэн, монголчуудын тэргэнд суурилуулсан хамгийн том гэр нь өргөөшөө гучин фут илүү том хэмжээтэй байсан бөгөөд түүнийг чирж явахын тулд 22 шар үхэр шаардлагатай байсан ажээ (Уильям Рубрук 1983). Марко Поло хэлэхдээ: “тэд нарын гэр дугараг хэлбэртэй бөгөөд сав мэт моддыг хооронд нь сайтар хэлхэн холбож бэхлээд, гадуур нь эсгийгээр бүрсэн байна. Гэр нь нүүх, суухад тохиромжтой, хөнгөн бөгөөд эвхэж хураагаад тэргэндээ тээж нүүдэг” гэжээ (Марко Поло 1981).

Их Монгол хаант улсаас эхлэн хойшоо Манж Чин улсын үед хүртэл Монголын өндөрлөгт хүзүүвчин тоонотой эсгий гэр нь бүрэн ажиллагаатай, боловсронгуй технологитой монгол гэр болон хөгжсөн байна. Чин улсын Энх-Амгалан хааны (Канси) 27 дахь жилд Жан Чен (张诚) Цахарыг дайран

өнгөрөхдөө: “Эдгээр майхнууд нь үнэндээ олон модон саваагаар бэхлэгдсэн дугуй сараалжин хананууд юм. Майхны дунд хэсэг нь илт өндөр бөгөөд дээвэр нь газраас дөрвөн фут орчим өндөрт баригдсан байж, төв хэсэгтээ нэг цэгт хүрч, цамхаг хэлбэртэй болдог” гэж бичжээ (Эрдэмт 2022).

Археологийн олдвор, түүхийн материалд шинжилгээ хийж нягтлан үзэхэд янз бүрийн үе шатанд байгаа Монгол гэрийн хэлбэрүүд өөр өөр байдаг ч зураг дээрх бүтэц, бүрээс, оосор, бүслүүр зэрэг гол материалуудын харьцуулалт, гэр барих арга зэргийг харьцуулан үзэхэд өнөөгийн хүртэл монгол угсаатанд олон зүйл хадгалагдан өвлөгдөж ирсэн болохыг нотолж болно. Монгол гэрийг барьж, буулгахад хялбар байдаг нь улирал солигдох, бэлчээрийн нөхцлийг даган нүүдэллэх, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангадаг. Энэ нь мөн ардын баялаг соёл, бэлгэдлийг агуулж байдаг. Гэрийн доторх зохион байгуулалт нь ахмад настнаа хүндэтгэн дээдлэх Монгол үзэл санааг агуулсан байдаг. Энэ нь гэр бүлийн уулзалт, нийгмийн үйл ажиллагаа, уламжлалт ур чадвар, түүхийг өвлөн үлдээх чухал орон зай, монгол соёлыг өвлөн үлдээх, залгамжлах түлхүүр юм.

Монгол гэрийн хийц, ур дэмийн уламжлал

Эртний Грекийн гоо зүйч Пифагор (Pythagoras, Грек: Πυθαγόρας) “Бүх гурван хэмжээст дүрсүүдээс хамгийн үзэсгэлэнтэй нь бөмбөрцөг, бүх хавтгай дүрсүүдээс хамгийн үзэсгэлэнтэй нь тойрог” гэж хэлжээ (Хегел 1979). Монгол гэрийн үндсэн бүтэц, дизайн нь Пифагорын тойрог, бөмбөрцөгт зориулсан гоо зүйн бишрэлийг бүрэн илэрхийлдэг. Монгол гэрийн дугуй хэлбэртэй загвар нь “Хавтгайрсан дүрст дугуй нь хамгийн үзэсгэлэнтэй” гэсэн ойлголттой нийцэхээс гадна практик үүрэг гүйцэтгэдэг. Дугуй бүтэц нь салхины хүчийг жигд тарааж, барилгын тогтвортой байдал, салхины эсэргүүцлийг нэмэгдүүлдэг. Гэрийн гурван хэмжээст загвар нь хагас бөмбөрцөгтэй ойрхон, орой нь бөмбөгөр хэлбэртэй бөгөөд гурван хэмжээст график дотроос хамгийн үзэсгэлэнтэй бөгөөд хамгийн бага талбайн доторх хамгийн том орон зайг багтаах чадвартай.

Хүн төрөлхтний соёлын биет өв болох монгол гэр нь:

1. Бүтцийн систем (Хана, унь, тооно, хаалга, багана зэрэг модоор хийсэн хэрэгсэл) нь нүүдэлчин ард түмний модульчлагдсан дизайны ухааныг илэрхийлдэг;
2. Оосор бүч, уяаны систем (хялгас дээс хийх гар урлал) нь холболтын технологийн хувьслыг тусгасан;
3. Эсгий бүрээс, ширмэлийн систем (Ноосоор эсгий хийх технологи) нь байгаль орчинд дасан зохицох материалын сонголт, урлаг гоо зүйг харуулдаг.

Архитектурын үүднээс авч үзвэл энэхүү систем нь технологийн хувьслын тодорхой шинж чанаруудыг харуулж байдаг. Дээд талын тоононы бүтэц нь энгийн хөндлөн модон хүрээгээс нарийн төвөгтэй дугуй цагираг хүртэл болсон нь технологийн үсрэлт бөгөөд түүний морфологийн хувьсал нь барилгын дээд хэсгийн механик шинжийг тасралтгүй сайжруулсныг харуулж байна. Төвийн унь систем нь шүхэр хэлбэртэй радиаль бүтцийг ашигладаг. Өнцгийг нарийн нягт тооцоолсноор таталцлын ачааллыг жигд дамжуулж, механик танин мэдэхүйн төлөвшсөн түвшинг харуулдаг. Хамгийн шинэлэг зүйл бол доод тулгуур хэсэг болох ханын хэсэг юм. Энэхүү эвхэгддэг сараалжин ханын бүтэц нь суурилуулах, буулгах, тээвэрлэх асуудлыг шийдэхээс гадна модульчлагдсан загвар нь барилгын цар хүрээг хэрэгцээнд нийцүүлэн уян хатан тохируулах боломжийг олгодог.

Техникийн үүднээс авч үзвэл, ханын геометрийн хэлбэр (дөрвөлжин эсвэл ромбо хэлбэр) нь математикийн зарчмуудыг агуулдаг. Түүний телескоп механизм нь бүтцийн тогтвортой байдлыг хангахаас гадна нүүлгэх, шилжүүлэх хэрэгцээг хангадаг. Бүхэл бүтэн бүтцийн тогтолцооны хувьсал нь үндсэндээ нүүдэлчин ард түмний архитектур дахь “хөнгөн авсааран” ба “бат бөх байдал”-ын үндсэн зөрчилдөөнийг арилгах бүтээлч шийдэл бөгөөд дэлхийн архитектурын түүхэнд өвөрмөц техникийн үнэ цэнэтэй юм.

Дүгнэлт

Монгол гэрийн хөгжлийг судлах нь эрдэм шинжилгээний болоод практик ач холбогдолтой. Юуны өмнө, Хүннүгийн гэрээс орчин үеийн гэр хүртэлх морфологийн хувьсал нь “дугуй, салхинд тэсвэртэй, хөнгөн, барьж буулгах, зөөж шилжүүлэхэд хялбар” гэсэн дизайны үндсэн үзэл баримтлалыг хангаж байсныг харж болно. Адил бус цаг үеийн эсгий гэрийн эд материал, талбайн зохион байгуулалт зэрэг нь Монголын өндөрлөгийн байгаль, цаг уур, түүнд тохирсон аж ахуй, нийгэм соёлын орчинд дасан зохицохын тулд нүүдэлчдийн технологийн тасралтгүй сайжруулалтыг тодорхой харуулж байна. Хоёрдугаарт, соёл хоорондын харьцуулсан судалгаанаас үзэхэд гэрийн хөгжил нь бас олон үндэстний соёлын солилцоог тусгаж байдаг. Юань улсын ордны асарт бий болсон хятад маягийн чимэглэл, Чин улсын үеийн гэрээс олдсон Төвөдийн буддын шашны хээ угалзтай хэсгүүд, орчин үеийн монгол гэрт шингэсэн орос маягийн ширмэн зуух зэрэг нь үндэсний соёлыг харилцан суралцаж буйн нотолгоо юм. Технологийн үүднээс авч үзвэл, гэрт агуулагдсан шинжлэх ухааны мэргэн ухааныг цаашид судлах нь зүйтэй. Түүний өвөрмөц модон бүтцийн систем нь дэвшилтэт

механик зарчмуудыг агуулсан, салгаж болох бүтэц нь модульчлагдсан дизайны санааг харуулж, уламжлалт байршил, орон зайн хуваарилалт нь одон зурхайн мэдлэгийг агуулж байдаг. Бичил ул мөрийн шинжилгээ, материалын сорилт зэрэг шинжлэх ухаан, технологийн аргуудын тусламжтайгаар эдгээр агуулгыг системтэйгээр илрүүлэн тайлбарлаж болно. Хойшид монгол гэрийн судалгаанд түүх, археологи, соёлын антропологи, дижитал технологи зэрэг аргуудыг нэгтгэсэн салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох шаардлагатай. Энэ нь нүүдэлчдийн архитектурын өвийг хамгаалах тогтолцоог сайжруулахад тус дөхөм болохоос гадна орчин үеийн тогтвортой архитектурын дизайны уламжлалт мэргэн ухааны лавлагаа болно. Архитектурын соёлын амьд өв болохын хувьд монгол гэрийн судалгаагаар дамжин хүний байгаль орчинд дасан зохицох олон талт байдлын талаар чухал ойлголтуудыг өгөх болно.

Abstract

Some remarks of research on the development of the Mongolian Ger

Bai Mandulatu

The Mongolian ger is one of the cultural treasures created by the nomadic people who have lived in the Mongolian highlands since ancient times. The Mongolian ger, a dwelling suitable for the lifestyle of the nomadic Mongolians, reflects the historical development and unique characteristics of the ethnic economy and culture, while preserving a vast intellectual cultural heritage. By studying the history, cultural significance, unique structural features, and changes in modern society of the Mongolian ger, a symbol of Mongolian nomadic culture, we can create architectural works that preserve national characteristics and modern feelings.

Keywords: Mongolian ger, architecture, sustainable development, and climate adaptability

Ном зүй

Баатархүү, Б., Одсүрэн, Д. (2015). Монгол гэр. Тайлбар толь. Улаанбаатар.

Вэй Жэнг (1962). “Сүй улсын судар: Түрэгүүдийн шастир”. Жүнхуа номын компани, х 241. 魏徵《隋书·突厥传》，中华书局1962年版，241页。

Гай Шанлин (1986). Иншан хадны зураг. Соёлын дурсгалт зүйлс хэвлэлийн газар, 盖山林/著《阴山岩画》IM]. 文物出版社1986年

Жан Тонг (2001). Монгол гэрийн үүсэл. Соёлын дурсгал, 52-56. 张彤. 蒙古包溯源[J]. 文物界, 2001(6):52-56.

Ли Хуэйз, Гао Сяошиа (2017). Гэрийн уламжлалт дээс зангилаа хийх технологийн судалгаа. Урлаг шинжлэх ухаан, 30(4): х 151-152. 李惠泽, 高晓霞. 蒙古包传统绳结制作工艺研究. 艺术科技, 2017, 30(4):151-152.

Лхүндэв, Г., Батболд, Г., Цогтбаатар, Б., Осава, Т., Отани, И. (2024). Хэрлэн голын сав газраас шинээр илрүүлсэн Түрэгийн язгууртны тахилын онгоны тухай. Археологийн судлал. Tomus XLIV, Fasc. 11, Улаанбаатар, 148-183.

Майдар, Д., Дарьсүрэн, Л. (1976). Гэр: Орон сууцны түүхэн тойм. Улаанбаатар.

Марко Поло (1981). Марко Пологийн аялал, орчуулсан, Фужоу: Фужиян шинжлэх ухаан технологийн хэвлэл, х 62. 马可·波罗《马可波罗游记》，陈开俊等译，福州市：福建科学技术出版社1981年版，第62页。

Мэн Чун рун, Тянь Жяшин (2023). Монгол гэрийн соёл, 2023, х 167,169,170 孟春荣、田嘉欣. 历史考据视角下蒙古包溯源, 研究文化·历史2023

Редакцийн хэлтэс (1992). Хятадын соёл иргэншлийн түүх: Сүн, Ляо, Жин, Юань гүрний үе, 7-р бүлэг: “Сүн, Ляо, Жин, Юань гүрний байгууллагууд ба нийгэм”, х 161-162 编辑部编辑（1992年）：《中国文明史 宋辽金时期》第七章〈宋辽金元的制度与社会〉，第161页-第162页。

Хегел (1979). Хегелийн гоо зүй, 3-р боть, Шанхай: Арилжааны хэвлэл, х 33. [德]黑格尔：美学 第三卷，朱光潜译，上海：商务印书馆1979年版，33页。

Хуан Вэйжунг (2022). Фулу, Чионглу: Төвөдийн соёлын солилцоо [J]. Хятад Төвөд судлал, (5): х 64-73+212-213. 黄维忠. 拂庐与穹庐——微观视野下吐蕃物质文化的双向交流[J]. 中国藏学, 2022, 154(5): 64-73+212-213.

Хятадын анхны түүхийн архив (2007). Хонконгийн Хятадын их сургуулийн соёлын өвийн музей. Чин гүрний эзэн хааны өрхийн журганы эмхэтгэл: 1-р боть [M]. Бээжин: Ардын хэвлэлийн газар, х 203. 中国第一历史档案馆, 香港中文大学文物馆. 清宫内务府造办处档案汇编:第一卷[M]. 北京:人民出版社, 2007:203.

Уильям Рубрук (1983). Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл. Бээжин: Хятадын Нийгмийн шинжлэх ухааны хэвлэл, х 112. 威廉·鲁布鲁克. 东游记[M]. 北京:中国社会科学出版社, 1983. 112.

Эрдэмт (2022). Монгол гэрийн архитектурын түүх: XIII-XX зууны дунд үе. Бээжин: Хятадын архитектур ба барилгын хэвлэл, 2022. х 34,33,48,84 额尔德木图. 蒙古包建筑史:13至20世纪中叶 [M]. 北京:中国建筑工业出版社, 2022年. 34, 33, 48, 84页

Эрдэнэбат, У., Амаргүвшин Ч. (2010). Дугуй Цахирын хадны оршуулга. Улаанбаатар.

Received: May 25, 2025; Revised: June 2, 2025; Accepted: June 7, 2025

